

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗӨВЛӨЛИЙН 01 ДҮГЭЭР ХУРАЛ**

2016 оны 01 дүгээр 21-ний өдрийн 09 цаг 20 минутад эхэлж, 10 цаг 45 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын танхимд хийж, нийт 1 цаг 25 минут хуралдав.

Д Д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Аймгийн хэмжээнд 2016 онд зохион байгуулах арга хэмжээнүүдийн нэгдсэн төлөвлөгөөний төсөл	Аймгийн хэмжээнд 2016 онд зохион байгуулах арга хэмжээнүүдийн нэгдсэн төлөвлөгөөний төслийг хэлэлцэх явцад гарсан саналыг тусгаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Б.Батмөнхөд үүрэг болгов.
2	Ховд аймгийг Монгол Улсын төрийн дээд шагнал “Сүхбаатарын одон”-гоор шагнуулах тодорхойлолтыг дэмжих тухай	Ховд аймгийг Монгол Улсын төрийн дээд шагнал “Сүхбаатарын одон”-гоор шагнуулах тодорхойлолтыг дэмжиж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Б.Батмөнхөд үүрэг болгов.
3	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс Ховд аймагт холбогдолтой хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн явцын тухай танилцуулга	Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс Ховд аймагт холбогдолтой хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг биелэлтийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, <a href="http://www.unelgee.gov.mn">www.unelgee.gov.mn</a> сайтад байршуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн Б.Гантөмөрт үүрэг болгов.
4	Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогын 2015 оны биелэлт	Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтийн биелэлтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Бат-Очирт үүрэг болгов.
5	Монгол улсын эдийн засаг нийгмийг 2015 хөгжүүлэх үндсэн чиглэлийн аймагт холбогдолтой заалтуудын биелэлт	Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн аймагт хамааралтай заалтын биелэлтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Бат-Очирт үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗӨВЛӨЛИЙН 02 ДУГААР ХУРАЛ**

2016 оны 01 дүгээр 25-ны өдрийн 15 цаг 30 минутад эхэлж, 16 цаг 40 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын танхимд хийж, нийт 1 цаг 10 минут хуралдав.

Д Д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Аймгийн “Сайн малчин”, “Тэргүүний тариаланч” шалгаруулах тухай	<p>1.Алтай сумын Алтангадас багийн малчин Догсомын Содгэрэл, Алтангадас багийн малчин Сүрэнжавын Отгонжав</p> <p>Булган сумын Далт багийн малчин Риймэдийн Дашдондог, Алагтолгой багийн малчин Цэвгээгийн Баатаржав</p> <p>Буянт сумын Цагаанбургас багийн малчин Доржхүүгийн Баянмөнх, Наранхайрхан багийн малчин Дашзэвэгийн Дамдинсүрэн, Нарийн гол багийн малчин Нямдаваагийн Нямбаяр, Цагаанбургас багийн малчин Жандалын Отгонбаяр</p> <p>Дарви сумын Мөрөн багийн малчин Батжаргалын Лхагвадорж, Баянбулаг багийн малчин Рагчаагийн Алтангэрэл, Мөнгөн аяга багийн малчин Цэдэндашийн Мягмарсүрэн</p> <p>Дөргөн сумын Аргалант багийн малчин Очирын Баярсайхан, Сээр багийн малчин Аюушийн Пүрэвдорж, Аргалант багийн малчин Шагдарсүрэнгийн Түвшинсайхан</p> <p>Дуут сумын Шивэр багийн малчин Бэжидийн Сүхээ, Цагаанбургас багийн малчин Зангиагийн Хасгаа, Хөхбэлчир багийн малчин Чулуунбатын Нэргүй, Шивэр багийн малчин Сэсээрийн Ганбат</p> <p>Зэрэг сумын Бургасан багийн малчин Батаагийн Ганхүү, Эхэн багийн малчин Цэрэнжавын Сүхбаатар, Бураа багийн малчин Баастын Баярсайхан, Гүвээ багийн малчин Баатарын Хүрэлдовчин</p> <p>Манхан сумын Баянгол багийн малчин Боовоогийн Болдоо, Тахилт багийн малчин Батмөнхийн Дагвасүрэн, Улаанхүрээ багийн малчин Сэсээрийн Нямаа, Тахилт багийн малчин Мандахын Дэмүүл, Баянгол багийн Ядамсүрэнгийн Бямбабаяр</p> <p>Мөст сумын Цэцэг гол багийн малчин Балдандоржийн Баясгалан, Баянхайрхан багийн малчин Сэрээтэрийн Пүрэвдорж</p> <p>Мөнххайрхан сумын Алаг багийн</p>

	<p>малчин Батлагын Чулуунбаяр, Хаг багийн малчин Эрхэмбаярын Эрдэнэбат</p> <p>Мянгад сумын Цагаанбулан багийн малчин Пүрэвийн Баттөмөр, Баянбулаг багийн малчин Баттулгын Бадам-Ёндон</p> <p>Үенч сумын Улиаст багийн малчин Ваашаагийн Норзоо, Нарийн гол багийн малчин Баастайн Баатархүү</p> <p>Ховд сумын Баянбулаг багийн малчин Хонгорбайн Бекболат, Баруун салаа багийн малчин Абилийн Бахытхан</p> <p>Цэцэг сумын Хажинга багийн малчин Цогоогийн Нямдорж, Баянгол багийн малчин Дашдоржийн Батсайхан, Баян-Овоо багийн малчин Баттулгын Баянмөнх</p> <p>Чандмань сумын Тахилт багийн малчин Жүгдэрийн Баттулга, Талын булаг багийн малчин Намхай-Очирын Батсайхан, Жаргалант багийн малчин Шагжын Мөнхтөгс, Баянхайрхан багийн малчин Чулуунбатын Энхмэнд, Сүлжээ багийн малчин Чадраабалын Гантөмөр</p> <p>Эрдэнэбүрэн Намарзан багийн малчин Туулайн Рэнцэндорж, Хонгио багийн Тэсвээгийн Гантөмөр, Шураг багийн малчин Надмидын Дэмчиг, Шураг багийн малчин Нансалмаагийн Пүрэвнамжил нарыг аймгийн “Сайн малчин”-аар</p> <p>2.Буянт сумын Норжинхайрхан багийн тариаланч Төмөрчулууны Баянмөнх, Ховд сумын Улаанбураа багийн тариаланч Адилханы Мырзахан, Эрдэнэбүрэн сумын Хар-Ус багийн тариаланч Даваажавын Буяндэлгэр, Булган сумын Далт багийн тариаланч Баастын Пүрэвдорж, Манхан сумын Төгрөг гол багийн тариаланч Хандсүрэнгийн Дансран нарыг аймгийн “Тэргүүний тариаланч”-аар тус тус шалгаруулахаар санал нэгтэй шийдвэрлэв.</p>
--	--

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗӨВЛӨЛИЙН 03 ДУГААР ХУРАЛ**

2016 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 08 цаг 30 минутад эхэлж, 09 цаг 55 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын танхимд хийж, нийт 1 цаг 25 минут хуралдав.

Д Д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Аймгийн “Алдарт уяач” шалгаруулах тухай	Уяж хурдлуулсан хурдан хүлгүүд нь аймаг, сумын үндэсний баяр наадамд олон удаа түрүү, айраг авч, аймгийн “Алдарт уяачийн” болзол хангасан уяачид, “Алтан хараацай” цолоор шагнагдах шилдэг унаач хүүхдүүдийн нэрсийг хавсралтаар санал нэгтэй дэмжиж шалгаруулахаар шийдвэрлэв.
2	Сум, баг, байгууллагын ажил дүгнэсэн дүнгийн тухай	2015 оны ажлаараа шалгарч сумуудаас тэргүүн байранд Зэрэг сум, дэд байранд Алтай сум, гутгаар байранд Мөст сум, тусгай байранд Эрдэнэбүрэн, Чандмань сумыг, байгууллагуудаас тэргүүн байранд Цагдаагийн газар, дэд байранд Ус цаг уур, орчны шинжилгээний алба, гутгаар байранд Боловсрол соёлын газрыг, багуудаас тэргүүн байранд Чандмань сумын Урд гол баг, дэд байранд Үенч сумын Хөх үзүүр баг, гутгаар байранд Булган сумын Далт баг, тусгай байранд Манхан сумын Төгрөг гол, Мөнххайрхан сумын Сэнхэр баг тус тус байр эзлүүлэхээр дэмжив.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗӨВЛӨЛИЙН 04 ДҮГЭЭР ХУРАЛ**

2016 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 16 цаг 05 минутад эхэлж, 17цаг 20 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын танхимд хийж, нийт 1 цаг 15 минут хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Аймгийн Хяналт-шинжилгээ үнэлгээний 2015 оны тайлангийн тухай	Аймгийн Хяналт-шинжилгээ үнэлгээний 2015 оны тайланг хэлэлцэх явцад гарсан нэмэлт саналуудыг тусган Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн Б.Гантөмөрт үүрэг болгов.
2	Төрийн үйлчилгээний байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжид өгөх хэрэглэгчийн үнэлгээний тайлангийн тухай	Төрийн бодлогын хэрэгжилт, төрийн байгууллагаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар хүртээмжид өгөх хэрэглэгчийн үнэлгээний тайланг аймгийн Хяналт-шинжилгээ үнэлгээний 2015 оны тайлангийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн Б.Гантөмөрт үүрэг болгов.
3	Аймгийн 9 алдартан шалгаруулах тухай	<p>1.Боловсролын салбарын алдартанаар-Уртнасангийн Саруулзаяа Жаргалант сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн захирал,</p> <p>2.Эрүүл мэндийн салбарын алдартанаар-Дамдинсүрэнгийн Бадамхорлоо Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн амаржих газрын төрөх тасгийн нярайн сувилагч</p> <p>3.Дэд бүтцийн салбарын алдартанаар-Баярын Болд "Ховд дулааны станц" ОНӨААТҮГ-ын захирал</p> <p>4.Санхүү, бизнесийн салбарын алдартанаар-Даваасамбуугийн Амгалантогтох "Төгс уян шил" ХХК-ний захирал</p> <p>5.Барилгын салбарын алдартанаар-Өлзийбаярын Түвдэндорж "Электро инсталэйшн" ХХК-ний захирал</p> <p>6.Байгаль орчин, ногоон хөгжлийн салбарын алдартанаар-Т.Пүрэвжав Хүнс, хөдөө аж ахуйн газрын мал эмнэлгийн хэлтсийн дарга</p> <p>7.Соёл, урлагийн салбарын алдартанаар-Мөнхбаярын Баатар Хөгжимт драмын театрын дарга</p> <p>8.Спортын салбарын алдартанаар-Түвшинбаярын Ариунзаяа Таеквондогийн спортын улсын шигшээ багийн гишүүн, спортын дэд мастер</p> <p>9.Хууль зүйн салбарын алдартанаар-Батбилэгийн Тамир Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга нарыг шалгаруулахаар санал нэгтэй дэмжив.</p>

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗӨВЛӨЛИЙН 05 ДУГААР ХУРАЛ**

2016 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 09 цаг 50 минутад эхэлж, 10цаг 20 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын танхимд хийж, нийт 30 минут хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Улсын тэргүүний сумын болзол хангасан Зэрэг сумын тодорхойлолт хэлэлцүүлэх тухай	Улсын тэргүүний сумын болзол хангасан Зэрэг сумын тодорхойлолтыг дэмжиж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Д.Дэлгэрбаярт үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР